



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/527

Хэрлэн сум

Төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах  
болон худалдан авах ажиллагаа зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 08 дугаар сарын 03-ны “Хариу хүргүүлэх тухай” 1а/3594 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хавсралтад Х.1.1.80 дугаартай батлагдсан “Олон улсын стандартын сургуулийн барилга, 640 суудал (Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон)” төсөл, арга хэмжээний материалын үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилтийн гэрээ байгуулах болон нэмэлт ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулсугай.

2. Төсөл, арга хэмжээний материалын үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилтийн гэрээ байгуулах болон нэмэлт ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах дүнг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
10 дугаар сарын 18-ны өдрийн  
Д/527 дугаар захирамжийн хавсралт

Багцын дугаар	Багцын нэр	Төсөвт өртөг (сая төгрөг)	2022 оны гэрээний дүн	2023 оны гэрээний дүн	2023 оны санхүүжих дүн (сая төгрөг)	Худалдан авах ажиллагаа зохион байгуулах эсэх
1	Олон улсын стандартын 640 суудалтай сургуулийн барилгын ажлын барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт (Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон)	7,058.5	5,962,904,167.0	1,095,625,007.0	1,095,625,007.0	үгүй
2	Ерөнхий боловсролын сургуулийн 640 хүүхдийн сургуулийн барилгын нэмэлт ажил (Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон)	1,795.9	-	1,742,053,533.0	1,795,926,700.0	тийм